



# ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

20 <sup>18</sup> оны <sup>01</sup> дугаар  
сарын <sup>19</sup> -ны өдөр

№ 01

Улаанбаатар хот

## Хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулж батлах тухай

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 28.8.28, Засгийн газрын 2011 оны 375 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 4.6-т заасныг үндэслэн Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2017 оны төсвийн урьдчилсан гүйцэтгэл, 2018 оны төсвийн хуваарийг хэлэлцээд 2017 оны төсвийн урьдчилсан гүйцэтгэлийг 53,5 тэрбум төгрөгөөр, 2018 оны төсвийн орлогын эх үүсвэрийг 87,2 тэрбум төгрөг, зарлагыг 65,3 тэрбум төгрөгөөр батлахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн даргад зөвлөмж болгосугай.

2. 2017-2018 онд хэрэгжүүлэхээр Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 01 тоот тогтоолоор батлагдсан “Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр”, “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”, “Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр”, “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-т хавсралтад заасан нэмэлт өөрчлөлтүүдийг оруулсугай.

3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдэд нэмэлт өөрчлөлт оруулсантай холбогдуулан хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдамж, арга хэмжээний нэгжид ногдох зардлын хэмжээ, хөтөлбөр арга хэмжээний гэрээний загварт зохих өөрчлөлт оруулж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад зөвлөсүгэй.

4. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2018 оны төсвийн хуваарийн 20-27 дугаар зүйлд заасан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр бий болгох төсөл, арга хэмжээг тухай бүрт шийдвэрлэн, зохион байгуулахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн даргад зөвшөөрсүгэй.


5. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2018 оны батлагдсан төсвийн хүрээнд санхүүжилтийг хуваарилан, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар /Б.Нямдаваа/-т, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, төслүүдийн хэрэгжилтийг мэргэжлийн удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллахыг Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Ц.Амартөгс/-т, хэрэгжилтийг хангаж, тайлагнаж ажиллахыг Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн зөвлөл, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн дарга нарт тус тус даалгасугай.

ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА,  
САЙД  С.ЧИНЗОРИГ

Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн  
дарга  Д.ХАДХҮҮ







## ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭНИЙ НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТҮҮД

### *Нэг. Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр*

- 1.1. 4.1-дэх “Тухайн иргэний онцлог, хэрэгцээг....” гэснийг “Тухайн иргэний онцлог, хэрэгцээг болон хөдөлмөр эрхлэх ур чадварыг.....”,
- 1.2. 4.1.2 дахь “..... харьцааны ур чадвар.... гэснийг “..... ажлын байранд дахь харилцааны ур чадвар...”,
- 1.3. 5.3.2. “Хөдөлмөр эрхлэлтийн сургалтын нэг хүнд ногдох зардлын жишиг хэмжээг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд батална”,
- 1.4. 5.3.3. “Ажил олгогч нь Улаанбаатар хотод Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газарт хүсэлтээ гаргах ба тус газар нь жилд 2 удаа зохих журмын дагуу нэгтгэн сонгон шалгаруулж, гэрээ байгуулан сургалтыг зохион байгуулна”,
- 1.5. 5.3.5. “Үйлдвэрлэл дээрх сургалт зохион байгуулж байгаа аж ахуйн нэгжид 10.0 сая хүртэл төгрөгийн сургалтын зардлыг нөхөн олгож болно” гэснийг “Үйлдвэрлэл дээрх сургалт зохион байгуулж байгаа аж ахуйн нэгжид 10.0 сая хүртэл төгрөгийн сургалтын зардлыг үр дүнгийн гүйцэтгэлд суурилан нөхөн олгоно” гэж тус тус өөрчлөх.

### *Хоёр. Ажлын байрыг дэмжих хөтөлбөр*

- 2.1. 4.1. “Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгийг олон нийтэд зарлан мэдээлэх, төсөл өгч хүсэлт гаргасан иргэдийг бүртгэн ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлж, төсөл боловсруулах болон аж ахуй эрхлэлтийн сургалтад хамруулсны дараа төслүүдийг шалгаруулах, төслүүдэд борлуулалтын болон ажлын байрны дэмжлэг үзүүлэх, төслийн үр дүнд хяналт-шинжилгээ хийх гэсэн үе шаттайгаар зохион байгуулна”,
- 2.2. 8.2-т “төрийн бус байгууллага” гэж нэмэх.

### *Гурав. Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр*

- 3.1. 4-т “..... туршилтаар .....” гэсэн үгийг хасах,
- 3.2. 4.1-д “Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь гарааны бизнесийг дэмжих арга хэмжээг дараах үе шаттайгаар жилд 1-2 удаа зохион байгуулна”. Үүнд:

- 3.2.1. Залуучуудын гарааны бизнесийг дэмжих ажлын хэсгийг<sup>1</sup> аймаг, дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөл, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс, холбогдох төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулан байгуулж ажиллуулна,
- 3.3. 4.1.4-д “... сонгон шалгаруулалтыг 72 цаг...”,
- 3.4. 4.1.5-д “Шалгарсан багуудын үйл ажиллагаа тогтворжиж, бизнесийн ашгаа хүртэж эхэлтэл /3 сар орчим/ бизнесийн зөвлөх /ментор/-үүдтэй хамтарч, гэрээний үндсэн дээр зохион байгуулна”,
- 3.5. Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгийн хугацааг уртасган 36 сар болгох,
- 3.6. 4.2. “Аймаг, нийслэл, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь гарааны бизнесийг дэмжих арга хэмжээг зохих дарааллын дагуу мэргэжлийн төрийн бус байгууллагатай гэрээний үндсэн дээр хамтран зохион байгуулна”,
- 3.7. 4.3-т “Залуучуудын гарааны бизнесийг дэмжих арга хэмжээг зохион байгуулах үйл ажиллагааны зардлыг шалгаруулалтын үе болон бизнесийн зөвлөх /ментор/ ажиллуулах зэрэг зардалд зарцуулах ба зөвлөх нь ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг, бизнесийн үйл ажиллагаа нь тогтворжсон ажил олгогч байж болно” гэж өөрчлөх.

*Дөрөв. Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр*

- 4.1. 2.2.3- дахь “.....24 сарын дотор ....” гэснийг “..... 36 сарын дотор.....” гэж өөрчлөх,

*Тав. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр*

- 5.1. 3.2.3-ийг “Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ганцаарчилсан болон бүлгийн зохион байгуулалттайгаар хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээнд хамруулна”,
- 5.2. 3.3.2-т “Шаардлагатай тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүсэлтийг харгалзан хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээнд хамруулах, ажлын ярилцлагад ороход туслах, ажлын байр, ажил олгогчтой танилцуулах зорилгоор хөтөч, дохионы хэлмэрч ажиллуулж болох бөгөөд хөтөч, дохионы хэлмэрч нь сургалтад хамрагдсан байна”,
- 5.3. 3.3.3-ыг “Хөтөч, дохионы хэлмэрч, чиглүүлэгч болон орон зайн чиг баримжааны сургагч багшийн цагийн ажлын хэлбэрээр ажиллах хугацаа нь жилд 800 цагаас хэтрэхгүй бөгөөд нэг цагийн хөлсийг тооцохдоо нийтийг хамарсан ажлын нэг цагийн хөлсний батлагдсан жишгийг 1,5 дахин нэмэгдүүлснээр тооцож, гэрээний үндсэн дээр олгоно. Үүнд: орон зайн чиг баримжааны сургагч багшийн ажлын үргэлжлэх хугацаа нь хэрэгцээнээс хамаарч 80 цагаас хэтрэхгүй байна.
- 5.4. 3.7.3. “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний онцлогт нийцүүлэн мэргэжлийн ур чадварын тусгайлсан сургалтыг Улаанбаатар хотод Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газар нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд мэргэжлийн сургалт зохион байгуулах дадлага, туршлага бүхий сургалтын байгууллагаар гэрээний үндсэн дээр зохион байгуулна”,

<sup>1</sup> Ажлын хэсгийн ажиллах нийтлэг удирдамжийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар батална.



- 5.5. 4.3.1-ийн “..... тохируулгатай .....” гэснийг хасаад “Тухайн хөгжлийн бэрхшээлтэй иргэний онцлогт нийцүүлсэн байнгын ажлын байр бий болгох зорилгоор боловсруулсан аж ахуйн нэгжийн төслийг зохих журмын дагуу шалгаруулж, хөгжлийн бэрхшээлтэй иргэний нэг ажлын байранд 5 сая хүртэл төгрөгөөр тооцон, 50 хүртэл сая төгрөгийг 100 хувь эргэн төлөгдөх нөхцөлтэй олгоно. Харин хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хангах, ажлын байр, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилго бүхий үйл ажиллагаа эрхэлдэг, ашгийн бус төрийн бус байгууллагын ажлын байр бий болгох төслийг зохих журмын дагуу шалгаруулж, хөгжлийн бэрхшээлтэй иргэний нэг ажлын байранд 5 хүртэлх сая төгрөгөөр тооцон 30 хүртэлх сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгоно”,
- 5.6. “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөл” нь төрийн болон төрийн бус байгууллагуудын саналд үндэслэн аж ахуйн нэгж болон төрийн бус байгууллагын тухайн жилд хэрэгжүүлэх төслүүдийн тэргүүлэх чиглэл, шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлж, шийдвэр гаргана. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь холбогдох хууль тогтоомжийн дагуу 4.3.1-д заасан төслүүдийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг жилд нэг удаа зохион байгуулах бөгөөд төсөл сонгон шалгаруулах үнэлгээний хороонд төрийн бус байгууллагуудын төлөөллийг “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөл”-ийн санал болгосноор шийдвэрлэнэ,
- 5.7. 4.2.1-д В. “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хангах, ажлын байр, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилго бүхий үйл ажиллагаа эрхэлдэг, ашгийн бус төрийн бус байгууллага нь 5 хүртэлх тооны хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг 12 сараас доошгүй хугацаанд байнгын ажлын байраар хангаж, нийгмийн даатгалын шимтгэлийг тасралтгүй төлсөн бол байнгын ажлын байраар хангасан хүний тоогоор тус тус урамшууллыг олгоно”,
- 5.8. 4.4-т “4.2.1-д заасан урамшуулалд хамрагдаж буй ажил олгогч, иргэнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бусад дэмжлэг, урамшууллыг давхардуулж олгохгүй” гэж тус тус нэмэлт өөрчлөлт оруулах.

-----oOo-----